



ТОЛБО СУМЫН БҮРЭН ДУНД СУРГУУЛИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас: 70422954
Цахим хаяг:

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахим хаяг:

Аудитор: Ж.Назгүл
Утас: 99668909
Цахим хаяг:

Хаяг: Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Байршил: Өлгий сум, 5-р баг,
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р
давхар

Цахим хуудас: www.audit.mn

2018 оны 2 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Толбо сумын бүрэн дунд сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Толбо сумын бүрэн дунд сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Толбо сумын бүрэн дунд сургуулийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 26-ноос 2 дугаар сарын 28-ны хооронд хийхээр төлөвлөн, аудитор Ж.Назгүл хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Толбо сумын бүрэн дунд сургуулийн 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 23-нд Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Аймаг дахь Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 26-нээс 2 дугаар сарын 28-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 28-нд Толбо сумын бүрэн дунд сургуулийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Толбо сумын бүрэн дунд сургуулийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай зэрэг хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан хүүхэд бүрийг мэдлэг боловсролтой, амьдрах ухааны чиг баримжаа бүхий эрүүл чийрэг, бүтээлч, бие хүн болгон төлөвшүүлнэ” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Толбо сумын бүрэн дунд сургуулийн дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Толбо сумын бүрэн дунд сургуулийн 2017 оны төсвийг Орон нутгийн төсвөөс Толбо сумын Төрийн сан дахь харилцах дансаар олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Толбо сумын бүрэн дунд сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Толбо сумын бүрэн дунд сургуулийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 27-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Толбо сумын бүрэн дунд сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж гаргаагүй байна.

Толбо сумын бүрэн дунд сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Толбо сумын бүрэн дунд сургуулийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Санхүү тооцоолох” ХХК-ны “Аколоус” санхүүгийн програмаар боловсруулан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Толбо сумын бүрэн дунд сургуулийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед 24 “их” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Тусгай зориулалтын шилжүүлгийн төсвөөс Төрийн сан дах харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Толбо сумын бүрэн дунд сургуулийн төсвийн захирагч нь 2017 онд 1357.0 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулжээ. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1357.0 сая төгрөгийн санхүүжилт авч, дээд шатны төсвийн захирагчаас 6.8 сая төгрөгийн, БСШУЯамнаас 203.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 12.1 сая төгрөгийн бараа материалыг үнэгүй авч, нийтдээ 1579.5 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр ажиллажээ.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзэхэд цалингийн зардал 55.5 хувь буюу 753.9 сая төгрөгийг, НДШ 6.1 хувь буюу 82,9 сая төгрөгийг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 15.4 хувь буюу 208.8 сая төгрөгийг, хангамж бараа материалын зардал 0.8 хувь буюу 11.5 сая төгрөгийг, нормативт зардал 9.1 хувь буюу 123.8 сая төгрөгийг, урсгал шилжүүлэг 12.3 хувь буюу 166.9 сая төгрөгийг эзэлж байна.

Шилэн дансны мэдээлэл

Толбо сумын бүрэн дунд сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг shilendans.gov.mn нэгдсэн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

ҮАГ-ын аудитын нэгдсэн төлөвлөгөөгөөр 2017 оны 11 дүгээр сард Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар 985.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Аудитын дүнгээр дутуу байршуулсан мэдээллийг бүрэн нөхөж мэдээллийн цахим хуудаст байршуулжээ. Шилэн дансны судалгааг shilendans гэсэн файлаар баримтжуулж, тайлантай хамт ажлын талбарт хавсаргав.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 27 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Үр дагаварыг тодорхойлж чадвал: Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг санхүүгийн тайланд залруулав.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Толбо сумын бүрэн дунд сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний санхүүжилт орлого, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин, халаалт, гэрэл цахилгаан, тээвэр шатахуун, нэг удаагийн тэтгэмж урамшуулал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тайлант оны онцлог гүйлгээний талаар тодруулбал:

Тайлант онд онцлохоор үйл явдал болоогүй байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг алдаа зөрчил илэрээгүй. Материаллаг дараах алдаа илэрсэн. Үүнд:

1. Үдийн цайг гэрээгээр гүйцэтгэгч байгууллагад 1062.6 мянган төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээс илүү зориулалт бус олгож Засгийн газрын 2012 оны 106 тоот тогтоол, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дах заалтыг тус тус зөрчсөн

Шийдвэрлэсэн нь: 1062.6 сая төгрөгийг гэрээгээр гүйцэтгэгч байгууллагаар нөхөн төлүүлэхээр акт тавив

2. Байгууллагын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байсан 2 ажилтанд Засгийн газраас олгосон 300000 төгрөгийн нэг удаагийн мөнгөн урамшуулалыг олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэл ногдуулсан, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байсан 2 ажилтнаар нөхөн төлүүлэхээр акт тавьсан

3. Хоолны зардлын батлагдсан төсвөөс сургуулийн захирлын 2017 оны 38 тоот тушаалаар бага олимпиадын багш сурагчдын хоолны зардалд 1530.0 мянган төгрөг, 54 тоот тушаалаар аймгийн санхүүгийн албаны ажилчдын туршлага солилцох арга хэмжээнд 1400.0 мянган төгрөг, 93 тоот тушаалаар шинэ жилийн баярын арга хэмжээнд 400.0 мянган төгрөгийг тус тус төсвийн зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулах зөвшөөрөлгүйгээр зориулалт бус зарцуулсан

Шийдвэрлэсэн нь: Сургуулийн захирлаар нөхөн төлүүлэхээр акт тавьсан

Материаллаг бус дараах алдаа зөрчил гарсан. Үүнд

1. Аймгийн ИТХ-аас баталсан 2017 оны тодотгосон төсвөөр батлагдсан орон тоо 104 боловч гүйцэтгэлээр 106 орон тоо ажиллуулсан байна. Шинээр 2 манаачийн орон тоог шинээр бий болгож, тэтгэвэрт гарсан 2 ажилтны орон тоонд шинээр 2 хүн томилж, тайлант онд шинээр 4 орон тоо бий болгожээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.3, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3 дах заалтууд болон УИХ-ын 2016 оны 69 дүгээр тогтоолын 3-ийн 1 дэх заалт, 2017 оны 29 дүгээр тогтоолын 6 дах заалудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн нэгдсэн тайлангаар албан шаардлага хүргүүлэх

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Залруулагдаагүй алдаа зөрчил гараагүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлыг алдаа зөрчлийн нэгтгэл маягтаар нэгтгэж харуулав.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

Зөрчилгүй санал дүгнэлт

Толбо сумын бүрэн дунд сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудас, хавсралтууд хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

М.ХУАНГАН 2018.02.28
Х.ЖЕНИСБЕК 2018.02.28
Ж.НАЗГҮЛ 2018.02.28

БЭЛТГЭСЭН: